

**Сумадираднаагийн тольд нэрийг
тайлсан тухай***

Д.Бүрнээ /МУИС/

19-20-р зууны монголын эрдэмтэн Сумадираднаа (Лувсанринчен /1820-1907/) бол хэл шинжлэл, түүхийн үнэтэй бүтээлүүдийг туурвисан нэрт орчуулагч, зохиолч, соён гийгүүлэгч хүн юм. Түүний зохиол бүтээлүүдийг монголыг судлагч эрдэмтэд өндөр үнэлж зохиол бүтээлдээ иш татсан байдаг. Сумадираднаагийн бүтээлүүдээс “Төвд монгол дохионы бичиг нэр, үг, утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч зул” хэмээх 1857 онд бичсэн бүтээл хүндтэй байрыг эзэлдэг бөгөөд монголчуудын дунд Сумадираднаагийн толь гэж алдаршсан билээ. Бид энэ өгүүлэлдээ Сумадираднаа “нэр” хэмээхийг хэрхэн авч үзсэнийг эхэлж тайлбарлаад улмаар “нэр”-ийг хэрхэн тайлсан тухай өгүүлэхийг зорьсон болно.

Сумадираднаа толь бичгийнхээ төгсгөлд бичсэн нь “...хамаг бодосыг дохио ба томъёонд шүтсэн нэрээр эс нэрийдвээс утгыг онон чадах бус бөгөөд нэрээр нэрийдэх нь утгыг мэдэхийн тулд бөлгөө. Дохионд хэдий чинээ судалваас эл төдий чинээ...утгад мэдэцтэй БОЛОХ...ДОХИО ба томъёонд эс мэргэжвээс ном ба ертөнцийн хоёр ёсны чухам байдалд мунхрах болоод мэргэдийн сууринаа суухуйяа зохисгүй..”(1) хэмээн нэр, утга хоёр салшгүй холбоотой хийгээд аливаа нэр дохио томъёонд шүтсэн байх учир утгыг мэдэхийн тулд “нэр”-ийг мэдэх хэрэгтэй, “нэр”-ийг мэдсэнээр сая мэргэдийн суудалд суух эрхтэй хэмээн онцлон тэмдэглэжээ.

Тэгвэл “нэр” гэж юуг хэлж байна вэ? “Нэр” нь өгүүлэгдэхүүний мөн чанарыг үзүүлнэ. “Үг нь нэрийг хурааж, утгын ялгаврыг өгүүлнэ” хэмээн Сумадираднаа “нэр” ба “үг”-ийг тодорхойлсон (2) бол монголын эрдэмтэн Агваандандар “...нэгэн үсэг төдийд өгүүлэгдэхүүнийг үзүүлэх чадал үгүй тул үсэг олон хурснаас нэр гарах болой” (3) хэмээн бичсэн байна. Энэхүү “нэр” хэмээсэн томъёо нь орчин цагийн үг хэмээх ойлголттой таарч байгаа бөгөөд “үг” хэмээсэн нь холбоо үг. өгүүлбэртэй дүйж байна.

* This work was supported by the Research Support Scheme of the Open Society Support Foundation, grant: №82/2000, "Religion, Nationality and Identity; A Comparative Study of Transforming Societies (Buryatia, Mongolia and Amdo)".

Сумадираднаа нэр, үг, утга гурвыг тодруулна хэмээсний тухайд үг, холбоо үг, өгүүлбэрийн утгыг тодруулна гэсэн хэрэг бөгөөд энэ тухай тэрээр бичсэн нь

“Төвдийн дохионы энэ наран ургаснаар
Дэмий л бус сургуулийн шавь нарын зөгийсөөр
Нэр үгсийн лянхуан цэцэглэгт
Тэмдэгтэйеэ утга нугуудын балыг амссаар баясан жиргэхийн дуун
Тэнгэрийн хэнгэрэг мэт дуурсгах нь юун за гайхамшиг бус” (4)

хэмээн төвд хэлний дохио нэр, үгсийн утгыг шинэхэн суралцагч багачууд үзэн баясах нь лянхуан цэцэглэгт зөгийс суугаад цэцэгсийн амтат балыг амтлан баясан жиргэх лүгээ адил хэмээжээ.

Тиймээс уг толийг *Төвд монголын дохионы бичиг нэр, үг, утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч* зул хэмээсэн нь төвд хэлний үг болоод холбоо үг, өгүүлбэрийн утгыг тайлж, үл мэдэхийн харанхуйг арилгах дохионы бичиг болохыг тодорхойлсон хэрэг юм. Ингэхдээ үл мэдэх мунхагийн харанхуйг арилгах дохионы бичгээ ертөнцийн балар харанхуйг гийгүүлэх зултай зүйрлэн *харанхуйг арилгагч зул* хэмээн нэрийдэж уг толийн агуулгыг тодотгожээ.

Дохионы бичигт уламжлалт нэр томъёогоор “нэр” тайлсан байдаг учир Сумадираднаагийн толь төвд монгол хоёр хэлний орчуулгын толь болно. (5) Харин энэ төрлийн толиос хамгийн олон үгийг хамарснаараа уг толь онцлог учир буриадын эрдэмтэн төвдөч Ц.Гомбожав, оросын эрдэмтэн М.Н.Богданов, монголын эрдэмтэн Б.Ринчен, Т.Пагва, Ц.Дорж нар бусад толиос “*нэр томъёог бүрэн дүүрэн хамарснаараа илүү давуутай*” гээр бас тайлбар толь болохыг онцлон тэмдэглэсэн байна.(6)

Сумадираднаа толь бичгийнхээ төгсгөлд бичсэн нь “*төвд монголын дохионы бичиг нэр, үг, утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч* зул нэрт үүнийг сургуулийн шинэ хүүхдэд туслахын саналаар бүхгүйгээс өдүүлж эртний мэргэдийн даяг нугууд маш хэрэглэгдэж байх боловч өчүүхэн хураангуй болсны тул нэмэлт болгон зорьж *төвд ба монгол хэлнээ нэмэр хадаж тайлаад* бус судар ба орны хэл хийгээд эгэл хар хэл ч чухал хэрэглэлтэй нүүгдийг олхоныг нэмэгч болж орчуулга мэдэхийн төдий болвоос тэр төдийхнөөр ч ялгуусан шашинд үйл үйлдсэн болох уу хэмээн сэтгээд сургуулийн яамны туслагч түшмэл Сумадираднаа бээр өөрийн тавин долоон насны дээр арван тавдугаар гал туулай улаагчин үхэр жилд найруулав”(7) гэжээ.

Төгсгөлийн үгээс үзвэл Сумадираднаа уг толио бурханы шашин, хамаг амьтны тусын тулд нэн ялангуяа “сургуулийн шинэ хүүхдэд туслахыг урьтал болгож бичсэн байна. Түүнчлэн тухайн үеийн төвд монгол толь бичгүүд товч хураангуй, цөөн үгтэй байсны учир *нэмэн дэлгэрүүлж* бичээд, *төвд ба монгол хэлнээ нэмэр хадаж тайлсан* хэмээжээ. “Монгол хэлний тайлбар толь”-д “тайлах” гэдэг үгийг үг, бичиг зохиолын утга санааг гүнээ дэлгэрүүлэн заахыг хэлнэ гэжээ. Зохиогч “*төвд ба монгол хэлнээ нэмэр хадаж тайлсан*” хэмээсэн нь төвд толгой үгийн утгыг бүрэн дүүрэн гаргах үүднээс төвд болоод монгол тайлбар хийснээ тэмдэглэсэн байна.

Сумадираднаагийн тольд төвд хэлний толгой үгсийг төвд цагаан толгойн дарааллаар байрлуулжээ. Толгой үгэндээ салангид үгээс гадна үг, холбоо үг, хэлц үг, өгүүлбэрийг ч хүртэл оруулж, утга дүйх монгол орчуулгыг хадахаас гадна нийт үгсийн гуравны нэг орчим хувийг тайлсан байна. Түүний тайлбарыг үндсэнд нь монгол тайлбар ба төвд монгол хадмал тайлбар гэж хоёр хувааж болно.

Монгол тайлбараа хийхдээ “Хорин нэгтийн тайлбар толь”ийг ашиглажээ. Тухайлбал төвд хэлний жоршин (skyor-shing) хэмээх үгийг монголоор *говчуур* хэмээн орчуулаад тайлсан нь; Говчуур гэдэг нь “хоёр модонд оосор хэлхэж, гэзгэвч сагалдарга хийж, малд ногт мэт өмсгөх ба хоёр модонд оосор хэлхэж малын хүзүүнд торгож тэрэг чирэхийг хийгээд **ширдэг ховчуурт** дээгүүр даран уях хоёр хавтгай модыг цөм говчуур хэмээмүй (8) гэжээ. “Хорин нэгтийн тайлбар толь”-д мөн үгийг тайлсан нь: “хоёр модонд оосор хэлхэж гэзгэвч сагалдарга тавин хийж, малд ногтын адил өмсгөхийг нь говчуур хэмээмүй. Бас хоёр модонд оосор хэлхэж малын хүзүүнд торгож тэрэг чирэхийг нь мөн говчуур хэмээмүй. Жич ширдэг говчиход дээгүүр даран уях хоёр хавтгай модыг бас говчуур хэмээмүй” (9) гэжээ.

Эндээс үзвэл “Хорин нэгтийн тайлбар толь”ийг ашигласан нь тодорхой байна. Ингэхдээ гурван богино өгүүлбэрийг нэг өгүүлбэрт зангидаж найруулсан байна.

Төвд хэлний жачүн (bya kyung) хэмээх үгийг Лувсанринчен гарди хэмээн орчуулаад тайлсан нь: **Гарьд-** “Өмнө бие хун адил, хойтохи бие хилингийн адил. могой хүзүүтэй, зааны сүүлтэй, луу мэт бидэртэй, яст мэлхий мэт артай. Тахиа хошуутай, өндөр нь зургаан тохойгоос илүү, Биед таван зүйлийн өнгө буй. Нисэхэд түмэн шувуу дагалцах хэмээмүй” (10) “Хорин нэгтийн тайлбар толь”-д **Гарьд- гайхамшигт шувуу, энх төвшний ёр, шувууны дотор эрхэм**, өмнөх бие хунгийн адил, хойтохи бие хилингийн адил, могойн хүзүү, загасны сүүл, луун бидэр, яст мэлхийн ар, тахианы хушуу, өндөр нь зургаан тохой илүү буй. Биед таван зүйлийн өнгө буй. **Эү-дүн мод бус болбоос суухгүй. Хулсан модны үр бус болбоос идэхгүй, амттайхан булаг бус болбоос уухгүй, нисвээс түмэн шувуу дэгалцмуй**” (11). Лувсанринчен “Хорин нэгтийн тайлбар толь-оос” үндсэн ухагдахууныг авч **гайхамшигт шувуу, энх төвшний ёр, шувууны дотор эрхэм...Эү-дүн мод бус болбоос суухгүй. Хулсан модны үр болбоос идэхгүй, амттайхан булаг бус болбоос уухгүй, нисвээс түмэн шувуу дагалцмуй** гэсэн нэмэлт тайлбарыг хасчээ. Ингэхдээ могойн хүзүү, загасны сүүл, луун бидэр, яст мэлхийн ар, тахианы хушуу гэсэн холбоо үгийн хүзүү, сүүл, бидэр, ар, хушуу зэрэг үгсийн хойно -тай, -тэй нөхцөлийг нэмэн залгаж найруулгыг засан сайжруулжээ. Харин тайлбар дотор загасны сүүлтэй хэмээхийг зааны хэмээн бичсэн, **ширдэг говчих** хэмээснийг “ширдэг говчуур” хэмээн алдаж бичсэн нь уг тайлбарын найруулгыг сулруулсан тал байна.

Ийнхүү алдаж ташаарсан буюу зөрөх зүйл байгааг хуулан бичигчийн алдаа байж болзошгүй гэж үзэж байна.

Монгол тайлбарыг ажиглавал ихэнхдээ монголын аж байдал, нүүдлийн соёлтой холбоотой үгс зонхилж бурхан шашны холбоотой үгс

ховор байна. Ийм монгол тайлбараас гадна төвд, монгол хадмал тайлбар бас байна. Хадмал тайлбараас жишээ татъя. Төвд хэлний “dkar na zho dmar na krag” хэмээх төвд ардын зүйр үгийг Лувсанринчен монголоор “цагаан болвоос тараг, улаан болвоос цус” хэмээн орчуулжээ.

Уг зүйр үгийг 1992 онд хэвлэгдсэн “Төвд ардын зүйр үг” номонд bden rdzun dkar nag gang yin gsal po bshad dgos pa'i dbe (12) буюу “үнэн худал, цагаан хар алин болохыг тодорхой өгүүлэх хэрэгтэйн үлгэр” хэмээн товч тайлбарлажээ. Үүнийг Сумадираднаа төвд хэлээр тайлсан нь: bsan-na bsan thag chod pa dang ngan na ngan thag chod pa zhig bya snyam du zhe bead drag po can zhig dgos pa'i don no. don bsdu na nyams su ten pa po phyir bsrings nas bsdad pas mi chog sde legs nyes gang yin rung mthar thon pa zhig bya snyam du zhe thag pa nas 'bad pa zhig dgos zhes pa'i don du sems so. Монголоор тайлсан нь “сайн болвоос сайныг шийдэх ба муу болвоос мууг шийдэн үйлдсүү хэмээн хатуу зоригт нэгэн хэрэгтэйн утга болой. Утгыг хурааваас анхааран авагч хойш тавьж суух хийгээд оюунаа үл зүглүүлэх хөшүүн ба шамдан хичээхгүй сул сууж үл болох бөгөөд сайн муу алин болов туйлд хүрэх нэгэн хэрэгтэй хэмээн үнэн зүрхнээс хичээх нэгэн хэрэгтэй хэмээхийн утга мөн” (13) хэмээжээ.

Эндээс үзвэл уг зүйр үг сайн мууг авах гээхийн ухаанаар сайтар ялгаж нэгэн үзүүрт сэтгэлээр сайныг дагаж сааргүй санасандаа хүрэх чухал хэмээсэн утгатай болохыг маш тодорхой тайлбарлажээ. Мөн Энэтхэгийн Магада улс дахи бурхан багшийн залрах орны нэр болох төвд хэлний *жагод пүн-бий ри* (bya-rgod-phung-pa'i ri) хэмээсэн үгийг *Хачир шувуу цогцолсон уул* хэмээн орчуулаад тайлсан нь: “хачир шувууны толгойн янзтайн тул хачир шувуу цогцолсон хэмээн алдаршсан, түүнд (бурхан Д.Б.) заларсан цагт нүгэлт шулмас бээр нэгэн хачир шувууны дүрсээр хувилж ирээд багшийн тавьсан номт дээлийг булаан авсанд бурхан (рид хувилгааны) хүчээр мөнхүү тэнд(ээ) огоорсон нь чулуу болж номт дээл(ийг) дөрөв давхарлаж эвхсэн мэт байснаар хачир шувуу цогцолсон хэмээн нэн үлэмж алдаршсан болой” (14) хэмээн бурханы шашны домгоос эшлэн тайлсан байна.

Мөн үгийг С.Ч.Дасын “Төвд Англи хэлний тайлбар толь”-д “Vulture-hill of Magadha, resort of Sakyamuni” буюу “Магада дахи тас шувууны дов, Шигэмүни бурханы залрах орон” (15) гэжээ. “Төвд Хятад хэлний тайлбар толь”-д *sangs rgyas sha'akya thub pas sher-phin gyi mdo gsungs pa'i sa cha rgya gar gyi ri zhig* (16) буюу “Бурхан Шагжтүв билиг барамидын номыг зарлигласан нэгэн уул” гэж товчхон тайлбарласан бол энэ хоёр тайлбартай харьцуулахад Сумадираднаагийн тайлбар дэлгэрэнгүй, бурханы шашны домог үлгэрийг эш үндэс болгосон нь илт байна.

Түүнчлэн төвд хэлний *agasta* хэмээх санскрит гаралтай үгийг тайлахдаа эн тэргүүн санскритаар галиглаж 1-рт соронзон гүр; 2-рт Усан тэнгэрийн хөвгүүн буюу *Рижи од* гэсэн хоёр үндсэн утгатай гээд *Усан тэнгэрийн хөвгүүн* буюу *Рижи-плли* домгийг өгүүлсэн нь (17) санскритаар **aractaya'a**, төвдөөр **ri-byi** нь *уул орхих* буюу *уул хаях* хэмээх бөгөөд **agas** нь *явахгүй* хэмээсэн үг бөгөөд уулын нэр, *taya'a орхих* буюу *хаяхад орох* ба тэр нь тэнгэрийн арш *Рижи* хэмээх зөн мэдэл рид хувилгаан төгөлдөр нэгний нэр мөн ба урьд цагт асури Лүнтов ба Сардан хэмээх ах дүү хоёр элдэв зүйлээр хувилж үйлдэгч гарсан бөгөөд Лүнтов бээр

өөрийн биеийг идээнд хувилгаснаас тэнгэрийн арш нугуудыг зочинд дуудаж залахуй бээр идсэн даруйд Сардан бээр түүнийг залгиж дуудваас аршийн ходоодыг хагалж гадагш гарсны үүднээс тэнгэрийн арш олныг алвай.

Түүнээс нэгэн цагт Рижийг зочлон дуудсан бөгөөд урьд мэт үйлдвээс Рижи бээр рид хувилгааны хүчээр Лүнтовыг гэдэсний дотор хайлуулж үйлдэв. Түүний хүчээр Рижи машид ундаассанаас далай ба бага ус бүгд(ийг) нэг оочоор уувай. Бас усан доторхи амьтанд нигүүлсэхүй сэтгэл үүсгэж ус нугуудыг бөөлжиснөөс миний уусан ус нугууд найман гишүүнт болтугай хэмээн ерөөл тавьснаар найман гишүүнт рашаан болов хэмээх урьдын домог үгэнд алдаршсан болой” (18) гэжээ. Сумадираднаа энэ тайлбартаа асури ба тэнгэр нар хоорондоо ямагт дайтаж байдаг тухай домгийг ашиглажээ.

Уг домогт өгүүлснээр Лүнтов ба Сардан хэмээх ах дүү хоёр асури элдэв зүйл рид хувилгааныг сурч байна. Тэд өөрсдийн биеийг идээнд хувилгах эрдэмд суралцаад тэнгэрийн арш нарыг урин зална. Тэнгэрийн арш нар тэднийг идээнд хувилсныг мэдэлгүй идэж орхидог. Тэр даруй өнөөх тэнгэрийн арш нарын гэдсэнд хувилж орсон асури нар аршийн гэдэс дотрыг хагалж олон аршийг хөнөөнө. Тэр цагт Рижи хэмээх нэгэн тэнгэрийн аршийг асури нар бас урин залахад тэрээр рид хувилгааны хүчээр асури нарыг гэдсэндээ хайлуулж чадна.

Ингээд Рижи маш их цангасан учраас их бага хамаг ус, далайн усыг хүртэл нэгэн оочоор уудаг. Гэсэн ч усан доторхи хамаг амьтныг өрөвдөн нигүүлсэж уусан усаа бөөлжиж гаргахдаа уусан ус минь найман гишүүнт буюу рашаан усны найман зүйлийн шинж төгөлдөр болох болтугай хэмээн ерөөсөн учир найман гишүүнт рашаан буй болжээ гэсэн домог үлгэрээс үзвэл Рижи буюу Усан тэнгэрийн хөвгүүн хэмээн нэрлэсний учрыг Сумадираднаа тодорхой гаргажээ.

Цаашилбал **жавсүчи** (skyabs su mchi) (19) хэмээх үгийг *авралд орсугай* хэмээн орчуулаад тайлсан нь “Аврал нь шүтээн ба орон хэмээхийн утга мөний тул алинд шүтвээс гэмт явдал нугууд арилах болоод mchi-ийн үгний тусгал **газаца** хэмээх *явах* ба *одох* хийгээд орох тэргүүтнээ орох тул энэ үед явуулахаар орчуулсан мэт гурван эрдэнийг шүтээн болгон барьж өөрийн оюуныг түүний зүгт явуулах ба одуулах бөгөөд гурван эрдэнэд өр гол зүрхээ нотлон даалгах утга мөний тул түүгээр бөгөөс бурханд итгэмүй хэмээхийг бурханы аврал буюу ивээлд шүтэн орсугай хэмээн хэлээр унших цаг' сэтгэлээрээ сайн муу аль юун боловч бурхан минь өөрөө айлд хэмээж зүрхний угаас сэтгэлийн (сэтгэлээ) түшин даалгаж өгөх ба номд итгэмүй хэмээхэд санал сэтгэлээ номд зүглүүлэн авралд нь орсугай хэмээхийн үед ч дээд номыг анхааран авсугай хэмээн сэтгэлээр тангараглах ба бурсан хуврагуудын аврал ивээлд нь орсугай хэмээх үед бурсан хуврагууд дээд номыг ямар мэт суралцсан тэрхүү ёсоор би ч тэр мэт суралцсугай хэмээн сэтгэлээр тангарагласан нугууд нь итгэл явуулсны хэмжээ мөн болой. 'chi-ba нь орохоор орчуулсан мэтээр бөгөөс орсон хэмээх мөний тул аврал тэдгээрийг орох орон буюу шүтээн болгон барьж ивээлд нь орсон буюу шүтвээс тэр бээр гэмт явдал ба аюулаас аврагдаад сайн газарт хөтлөгдөх тул авралд түшин орж итгэмүй хэмээсэн мөн болой.

Өөрөө зовлонгоос айж түүний арга эрэх цагт лам хийгээд бурхан хоёр нь түүний аргыг зааж үзүүлэгч мөний тул бурхан нь авралыг заан үзүүлэгч хэмээх ба хувраг ч эртний сайн номтон нугуудаар номыг эдэлсэнд шүтэж муу заяанаас тонилсон домог нугуудаар жишиж дээдсийг дууриах ёсоор өөрөө ч түүн лүгээ адилаар даган суралцсан хувраг нөхөр хань, аврал итгэл бүтээхийн нөхөр хань мөн хэмээн номлосон мэт бусдад онол төрсөөр буй ч өөрийн зохилдох нөхцөл мөн бөгөөд өөрөө ч түүний тоонд орвоос туст хэмээн номлов.

Тэр мэт авралыг үзүүлэгч ба бүтээх хань нөхрийн төдий мөний тул (бурхан) хувраг хоёр бодтой авран чадахгүй бөгөөд тиймийн тул аврагч бодтой аврал нь ном чухаг дээд бөгөөд ном түүнийг ч өөрөө үйлдэх хэрэгтэй бөгөөд эс үйлдвээс авран үл чадахын тул ном түүнийг өөрөө анхааран авахын дуршилыг үүсгэгдэхүй. Лам бээр бодтой гэгээнээр мөрийг үзүүлээд бурхан бээр дамжуулж үзүүлсэн тул лам хийгээд бурханд авралыг үзүүлэгчийн ёсоор ба бурсан хуврагт мөрийн *jdeXep* болохыг өчихийн ёсоор итгэл явуулагдахуй. Гурван авралын хураангуйн мөн чанар лам мөн нь, ламын бие бурсан хувраг, зарлиг нь ном, сэтгэл нь бурхан чухаг дээд мөн болой” (20).

Ийнхүү Сумадираднаа *авралд орсугай* хэмээх холбоо үгийг тайлахдаа эхлээд *аврал, орох* хэмээх хоёр үгийн утгыг тус тусад нь тайлбарлаад эл нийлэмж үгийн гүн чанад утгыг нарийн тайлжээ. Тухайлбал, авралд орно гэдэг нь угтаа чанад утгандаа чухаг дээд гурав буюу бурхан, хувраг, ном гуравт итгэж шүтэхийг хэлж байгаа бөгөөд ийнхүү итгэж шүтэхийн учир нь тэдгээрийг шүтсэнээр аливаа аюул зовлонгоос аврагдаж сайн газарт хөтлөгдөнө. Авралыг эрэхийн тулд эн тэргүүн номд (бурханы шашинд, бурханы сургаалд Д.Б) итгэл явуулах улмаар бурсан хувраг, бурханд итгэл явуулах нь зохистой гэх мэт итгэл явуулахын утга учир, итгэл явуулахын үе зэрэг тэргүүтнийг тодорхой тайлжээ.

Ийнхүү энэ тольд буддын шашин, гүн ухааны холбоотой үгс олон байгаа бөгөөд эдгээрийг тайлахдаа дээр өгүүлсэнчлэн *төвд ба монгол хэлнээ нэмэр хадаж тайлсан* бөгөөд энэ тухай зохиогч бичсэн нь

“Төлбөрөхүйт би мэт бээр аль саналдаа ургасан бүгдийг бичсэн

энэ

Төлөгч гахайн толгойтын үлгэр мэт
Төсөөтэй сайны хувь зарим байхул
Төгс билигтэн баясахуйн баяр хурим болгосугай
Шинэ сургуулийн хүүхдийг баясгахаар энэ даягийг зохиохдоо
Шалгадаг олон голуудыг сонссоны хүчин дорой боловч
Шулуун буянт саналаар энэ мэт үйлдсэнд
Шуудварт гэмүүд хэдий буйг мэргэд хүлцэн үйлд” (21)

хэмээн өөрийн оюунд ургасан бүхнийг үзэж судалсан ном судартаа түшиглэн тунгаан бясалгаж, хамаг амьтанд туслах санааг агуулан бичсэнээ дурдахын хамт уншигч оюутан мэргэд алдаа мадаг байх ахул шүүн тунгаана уу хэмээн эгэл даруугийн ёсоор хүлцэлийг эрэн бичжээ. Сумадираднаа тайлбараа хийхдээ “Бодичарьяаватара” буюу “Бодисадын явдалд орохуй”, “Үлгэрийн номын шагшаабадын зүйл”, “Нирвааны судар”, “Онъсон саран гэрэлт”, “Үлгэрийн ном”, “Тус тус тонилохуйн

судар”, “Судрын аймгийн чимэг”, “Оньсон сарны гэрэлт”, “Чуулганы эзний домог” тэргүүтэн олон ном судрыг ашигласнаа бас дурдсан байна.

Ийнхүү Сумадираднаа “Төвд монголын дохионы бичиг нэр, уг, утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч зул” хэмээх энэхүү дохионы бичигтээ уламжлалт толь бичгүүдийг ашиглаж буддын их бага таван ухааны ном зохиол, үлгэр домог, ардын зүйр цэцэн үг тэргүүтнийг хүртэл үзэж судалж нэрийг тайлахдаа товчлон хураангуйлах, засан найруулах зэргээр бүтээлч боловсруулалт хийснээс гадна өөрөө ч слон тайлбарыг зохиожээ.

Зүүлт

1. Sumadiratna. Tiibed mongyol dokiyan-u bicig ner-e iige utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyauci jula, Ulaanbaatar, Vol.II, 1959, 1389-р тал.
2. Sumadiratna. Tiibed mongyol dokiyan-u bicig ner-e iige utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyauci jula, Ulaanbaatar, Vol.II, 1959, 433-р, 579-р тал.
3. Ngag dbang bstan dar, Yi ge'i bshad pa mkhas pa'i kha rgyan. Mi rigs dbe skrun khang, 1992, 24-р тал.
4. Sumadiratna. Tiibed mongyol dokiyan-u bicig ner-e iige utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyauci jula, Ulaanbaatar, Vol.II, 1959, 1385-р тал.
5. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар, 1966, 193-р тал; О.Сүхбаатар. Монгол хэлний харь үгийн толь, Улаанбаатар, 1997, 83-р тал; Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн судлалын үндэс. Улаанбаатар, 1986, 195-р тал.
6. Б.Д. Баяртуев. Жизнь и творчество Ринчена Номтоева (1820-1907) В кн.; Буддизм и литературно-художественное творчество народов Центральной Азии. Новосибирск 1985, стр. 78-84.; Т.Пагва. Монголын хэлзүйч-эрдэмтэн Сумадирадна (Лувсанринчен)-гийн бүтээлүүдийн товч тойм. Монгол хэл шинжлэлийн зарим асуудал. МУИС, Монгол Судлалын дээд сургууль, Эрдэм шинжилгээний бичиг, БОТЬ 11 (134), УБ., 1998, 71-72-р тал.; Ц.Дорж. Төвд монгол дохионы бичиг, түүвэр нэрсийн тухай. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал. 1-р дэвтэр, ШУАХ.УБ., 1951, 104-105-р тал.; А.М.Позднеев. Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии в связи с отношениями сего последнего к народу, Элиста 1993, стр. 23.
7. Sumadiratna. Tiibed mongyol dokiyan-u bicig ner-e iige utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyauci jula, Ulaanbaatar, Vol. II, 1959, 1389-1390-р тал.
8. Sumadiratna. Tiibed mongyol dokiyan-u bicig ner-q iige utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyauci jula, Ulaanbaatar, Vol.I, 1959, 133-р тал.
9. Qorin nigetii tayilburi toll, Obiir mongyol-un arad-un keblel-iin qoriy-a, 1979.

10. Sumadiratna. Tiibed mongyol dokiyan-u bicig ner-e uge utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyayci jula, Ulaanbaatar, Vol.II, 1959, 215-р тал.
11. Qorin nigetu tayilburi toll, Obiir mongyol-un arad-un keblel-iin qoriy-a, 1979.
12. Rgyun sbyod bod rigs gтам dbe bsags mdzod. Mi rigs dbe skrun khang, 1992, 6-р тал.
13. Sumadiratna. Tubed mongyol dokiyan-u bicig ner-e iige utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyayci jula, Ulaanbaatar, Vol.I, 1959, 53-р тал.
14. Төвд тайлбар нь: ri bya rгод-kyi mgo bo 'dra bas bya rгод phung por grags pa'i ri de la gshegs pa na /bdud kyis bya rгод kyi gzugs su sprul nas/ ston pa'i chos gos phrogs pa dang/ sangs rgyas kyi mthus de nyid du bor ba rdor gyur nas bzhi rim byas te chos gos lta bur 'dug pas bya rгод kyi phung por cher grags so. Sumadiratna. Tiibed mongyol dokiyan-u bicig ner-e iige utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyayci jula, Ulaanbaatar, Vol.II, 1959, 215-р тал.
15. S. Ch.Das. Tibetan-English dictionary. Third reprinting. Compact Edition, Japan, 1977, p. 880.
16. Bod rgya tshig mdzod chen mo. Bar cha. Mi rigs dbe skun khang, 1985, 1856-р тал.
17. Төвд тайлбар нь: a gasta ste khab len /a gastya'a ri byi/ ni ri 'dor ram ri 'phen zhes pa ste /a gas ni 'dro med de ri'i ming dang/ tya'a 'dor ba'am 'phen pa la 'jug pa/ de ni lha yi drang srong ri byi zhes bya ba mngon shes rdzu 'phrul dang ldan pa gcig gi ming yin te/ sngon gyi dus SU lha ma yin rlung thob dang sar ldang zhes bya ba sbun gnyis sprul bsgyur sna tshogs byed pa zhig byung ste /rlung thob kyis rang lus zas SU sprul nas lha'i drang srong rnam mngon du bos te drangs pa zos ma thag sar ldan gyis de'i ming nas bos pa na drang srong gi lto ba dral te phyr byung ba'i sgo nas lha'i drang srong mang po bsad/ de has nam zhig n a ri byi mngon la bos te/ sngar ltar byas pa na ri byis rdzu 'phrul gyi stobs kyis rlung thob khog pa'i nang du zhus par bya/ de'i stobs kyis ri byi shin tu skom nas rgya mtsho dang chu phran mtha' dag hub gcig gis 'thung/ slar chu nang gi srog chags snying rje'i sems bskyed de chu rnam skyugs nas bgag gis 'thungs pa'i chu rnam yan lag brgyad ldan du gyur cig ces smon lam ltab pas yan lag brgyad ldan gyi bdud rtsir gyur to zhes sngon gyi gтам rgyud la grags pa'o.
18. Sumadiratna. Tiibed mongyol dokiyan-u bicig ner-e iige utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyayci jula, Ulaanbaatar, Vol.II, 1959, 1344-1345-р тал.
19. Төвд тайлбар нь: Skyabs ni rten pa dang gzhi zhes pa'i don yin pas gang la brten na nyes spyod mams dag par 'gyur zhing/ mchi ba'i skad dod gatsatsha zhes pa 'gro ba dang song ba dang zhugs pa sogs la 'jug pas skabs 'dir 'gro ba la bsgyur ba ltar/ dkon mchog gsum rten du bzung nas rang gi bio de'i' phyogs su 'gro ba dang song ba ste/ dkon mchog gsum la bio snying 'gel ba'i don yin pas/ de nas sangs rgyas la skyabs su mchi'o zhes ngag nas 'don pa'i skabs su yid kyis legs nyes ces byung yang sangs rgyas rang mkyen snyam du snying thag pa nas bio 'gel ba dang/ chos la skyabs su mchi'o zhes

- pa'i skabs su yang dam pa'i chas de nyams su blang bar bya'o zhes yid kyis dam lea' ba dang / dge 'dun la skyabs su mchi'o zhes pa'i skabs su dge 'dun nams kyis dam pa'i chos la ji ltar slob pa bzhin du bdag gis kyang de ltar bslab par bya'o zhes yid kyis dam boa' ba nams skyabs su song ba'i tshad yin no/ 'chi ba ni zhugs pa la bsgyur ba ltar na/ zhugs pa zhes pa yin pas skyabs te 'jug yul la ma rtendu zhugs pa'am brten pa na des nyes spyod dang 'jigs pa las skyob cin bzang sar 'khrid pas skyabs su mchi zhes pa yin no/ rang nyid sdug bsngal las 'jigs nas de'i thabs btsal ba'i tshe bla ma dang sangs rgyas ni de'i thabs sdon mkhan yin pas sangs rgyas skyabs sdon pa po dang dge 'dun yang sngon gyi chos bzang po dag gis chos spyad pa la brten nas ngan song las thar pa'i lo rgyus dag la dpag nas kha mig yar bitas tshul gyis rang yang de dang 'dra bar rjes su slob pa'i dge 'dun zla grogs skyabs sgrub pa'i zla grogs su su gsung ba ltar gshan la rtogs pa skyes szhin yod pa yang rang gi mthun rkyen yin te/ rang yang de'i' grangs su 'jug pa'i' phan gsungs de ltar skyabs ston pa po dang sgrub pa'i zla grogs tsam yin pas sangs rgyas dang dge 'dun gnyis kyi dngos su skyobs mi nus mi thub la/ de'i phyir skyob byed skyobs dngos ni chos dkon mchog ste de yang rang gis bya dgos te ma byas na skyob mi thub pa'i phyir/ de nyid rang gis nyams su len pa'i 'dun pa bskyed par bya'o bla mas dngos su lam ston cing sangs rgyas kyis brgyud nas ston pas bla ma dang sangs rgyas la skyabs ston pa po'i tshul du dang/ dge 'dun la lam gyi grogs zhu ba'i tshul du skyabs su 'gro bar bya'o/ skyabs gsum kun 'dus kyi bdag nyid bla ma yin no/ bla ma'i sku dge 'dun gsung ni chos/ thugs ni sangs rgyas dkon mchog yin no/
20. Sumadiratna. Tiibed mongyol dokiyan-u bicig ner-e uge utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyayci jula, Ulaanbaatar. Vol.I. 1959, 112-116-p тал.
 21. Sumadiratna. Tiibed mongyol dokiyan-u bicig ner-e uge utqa yurban-i todurayulun qarangqui-yi arilyayci jula, Ulaanbaatar, Vol.II, 1959, 1386-p тал.

Summary

In this article we considered explanations of «ner» or words compiled by mongolian scientist Sumadiratna (1820-1907). On the basis of examples we tried to prove that Sumadiratna's explanations are extensive and have deep meaning.

